

МОНИНЖБАР ХУВЬЦААТ КОМПАНИЙН 2015 ОНЫ

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

2015 оны 04 сарын 15

Улаанбаатар хот

Эрхэм хувь нийлүүлэгчидээ!

Эрхэм Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдээ!

Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэхийн ялдамд компанийн гүйцэтгэх удирдлага болон үйл ажиллагааг дэмжин ажилладагт талархаж байгааг хүлээн авна уу.

2015 онд компани 30 гаруй тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий тендер шалгаруулалтад оролцож 9,42 тэрбум төгрөгийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэх гэрээ байгуулах эрхийг авсан боловч улс орны эдийн засаг хямарч, санхүүгийн байдал хүндрэн, улсын төсвийн орлого тасалдсанаас 6,2 тэрбум төгрөгийн барилга угсралтын ажлыг гүйцэтгэлээ.

- 2015 онд шинээр болон үргэжлүүлэн гүйцэтгэсэн барилга угсралтын ажлын талаар товч танилцуулахад:

1.Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж байгаа “Шинэ бүтээн байгуулалт “ дунд хугацааны зорилтот хөтөлбөрийн хүрээнд ” Шинэ яармаг” орон сууцны хорооллын 15 км цэвэр усны шугам сүлжээг зураг төслийн хамт “Инженерийн дэд бүтэц концерциум” ХХК-ийн хүрээнд гүйцэтгэх гэрээг 2015 оны 06 сарын 05 өдөр байгуулж Монинжбар ХК нийт ажлын 70 хувь буюу 3,22 тэрбум төгрөгийн ажлыг 2015 оны 07 сарын 20-ноос 2015 оны 09 сарын 20-ны хооронд маш богино хугацаанд чанарын өндөр үзүүлэлттэйгээр гүйцэтгэж ашиглалтад хүлээлгэн өглөө.Уг ажлын санхүүжилт нь төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр Монгол улсын Хөгжлийн банкнаас санхүүжсэн бөгөөд гүйцэтгэлийн санхүүжилт хийх хугацаа хойшлогдож удаашралтай явагдаж байсан боловч ондоо багтаан бүх санхүүжилтыг авч чадсан байна. Барилга угсралтын явцад гэрээ байгуулж зургын ажлыг дуусгаж ажил эхлэх хүртэл 2 сарын хугацаанд валютын ханш огцом өөрчлөгдөж 1 юанийн ханш 316 төгрөгөөс 320 төгрөг болж өссөнөөс шалтгаалан гадаадаас импортоор худалдан авдаг бараа материалын үнийн зөрүүгээс 14,0 орчим сая төгрөгийн алдагдалыг хүлээсэн байна.

Тухайн ажлыг гүйцэтгэхэд компанийн бүх инженер техникийн ажилчид, машин механизмыг 4 бригад болгон өндөр бүтээлийн аян зарлаж ажилласан нь ихээхэн үр дүн өгсөн.

1. Азийн хөгжлийн банк болон Монгол улсын төсвийн хөрөнгө оруулалтаар /49 хувь нь АХБ, 51 хувь нь улсын төсөв/ хөрөнгө оруулалтаар Өмнөговь, Дорноговь аймгийн хил орчмын суурин газрын дэд бүтэц хөгжүүлэх төслөөс зарласан Өмнөговь аймаг Цогтцэций сумын төвийн ус хангамж, ариутгах татуургын шугам, усан сан, бохир усны насос станц, ус түгээх байр, барилга угсралтын ажлыг гүйцэтгэх сонгон шалгаруулалтанд ялж 2014 оны 05 сарын 27-нд 1,1 сая ам долларын өртөг бүхий G0204-MON тоот гэрээг байгуулсан. Уг гэрээт ажлыг 2014 оны 05 сарын 27-ноос 2014 оны 12 сарын 25-ныг хүртэл барилга угсралтын ажлыг 95 хувьтай гүйцэтгэн техникийн комисс ажиллуулж 2015 оны 06 сарын 01-нийг хүртэл улсын комисс ажиллуулах хүртэлх хугацаагаар гэрээг сунгасан. Барилга угсралтын гэрээг сунгасан шалтгаан нь гүйцэтгэгчээс шалтгаалаагүй бөгөөд зураг төсөвт өөрчлөлт орж сумыг ундны усаар хангахад одоо ашиглагдаж байгаа Ухаа худаг-Ус хангамж ХХК-ийн шугамаас огтолгоо авахаар шийдвэрлэж шинээр техникийн нөхцөл авах шаардлагатай болсон. Мөн бохир усны насос станцаас Энержи ресурс ХХК-ийн цэвэрлэх байгууламжтай холбогдох холболтын техникийн нөхцөл авах шаардлагатай болсон бөгөөд эдгээр техник нөхцөлүүд нь 2014 оны 12 сарын 25-нд гарсан тул өвлийн улиралд шугам сүлжээний холболт хийх бололцоогүй технологийн горим зөрчигдөхөөр байсан тул эдгээр үлдэгдэл холболтын ажлыг 2015 оны 05 сард гүйцэтгэн 06 сарын 01-ны дотор улсын комисст хүлээлгэн өгөхөөр гэрээ сунгагдсан. Хэдийгээр барилга угсралтын ажлын 95 хувийг гүйцэтгэсэн боловч улсын төсвийн орлого бүрдүүлэлтээс шалтгаалж улсын төсвөөс санхүүжигдэх хөрөнгө оруулалт тасалдаж 2014 онд ямарч санхүүжилт хийгдээгүй. Тухайн ажлыг гүйцэтгэхэд Азийн хөгжлийн банкны санхүүжилтийг бүрэн авч нэмж банк бус санхүүгийн байгууллагаас 300 сая төгрөгийн зээлийн эх үүсвэрээр гүйцэтгэсэн.

2015 оны 05 сарын 01-ны өдрөөс төслийн үлдэгдэл ажил болох шугам сүлжээг эх үүсвэртэй холбох ажлыг гүйцэтгэн 06 сарын 01 ны өдөрт багтаан улсын комисст хүлээлгэн өгч АХБ-ны шийдвэр гаргах эрх бүхий 13 захирлаас 9 захирал, Барилга, хот байгуулалтын сайд Б.Цогтбаатар болон албаны хүмүүс оролцсон нээлтийн үйл ажиллагааг Цогтцэций сумын төвд хийж, төслийн гүйцэтгэлийн чанар, богино хугацаанд гүйцэтгэсэн, орон нутгийн удирдлага, ард иргэдийн сэтгэл маш өндөр байсан нь компанийн нэр хүндэд ихээхэн эерэг нөлөө үзүүллээ.

Урд онуудад барилга угсралтын ажлыг гүйцэтгэн техникийн болон улсын комисс ажилласан боловч гүйцэтгэгчээс хамааралгүй зураг төсөв, хэрэглэгчгүй, ашиглагч байгууллага тодорхойгүй, барилга угсралтын явцад зайлшгүй хийгдэх ёстой нэмэлт ажлууд гарч үүнтэй уялдан санхүүгийн нэмэлт эх үүсвэрийг холбогдох яам, захиалагчаар шийдүүлэх гэсэн шалтгаануудын улмаас зогсонги байдалд орсон дараахи объектууд зармыг хүлээлгэн өгч зарим объектын хугацааг сунгах, нэмэлт хөрөнгийг шийдүүлэхээр хандаад байна. Үүнд:

2. Монгол улсын Хөгжлийн банкны санхүүжилтээр Баянголын амны орон сууцны хорооллын дулааны шугамын өргөх насос станцын барилга угсралтын ажлыг 2013-2014 онд 3,45 тэрбум төгрөгөөр гүйцэтгэхээр 2013 оны 07 сарын 16-нд гэрээ байгуулж барилга

угсралтын ажлын 95 хувийг гүйцэтгэн техникийн комисс ажиллуулсан. Уг гэрээт ажлыг гүйцэтгэгч компани 100 хувь гүйцэтгэн улсын комисс ажиллуулахад бэлэн байгаа боловч гүйцэтгэгчээс шалтгаалахгүйгээр дараах хүндрэлүүд үүсч Эрчим хүчний яам, төслийн нэгж, гүйцэтгэгчид 3 талт гэрээ байгуулан улсын комисс ажиллан байнгын ашиглалтанд оруултал харуул хамгаалалтыг гүйцэтгэгч компани хариуцахаар царцаалаа. Үүнд:

- Ашиглагч байгууллага өнөөг хүртэл тодорхой бус
- Насос станц руу очиж байгаа дулааны дамжуулах шугам үерт
автаж энэ хэвээр ашиглах боломжгүй болсон.

- Дулааны шугамыг хэрэглэх хэрэглэгч одоогоор байхгүй. Эдгээр шалтгааны улмаас тухайн объектыг тодорхойгүй хугацаагаар ашиглалтад оруулалгүй харуул хамгаалалтын гэрээг дахин 3 жилээр сунгалаа.

3. Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн Ногоон зоорь орчмын орон сууцны хорооллын гадна цэвэр усан хангамж, усан сан, насос станцын барилга угсралтын 2-р ээлжийн ажлыг 1,12 тэрбум төгрөгийн санхүүжилттэйгээр 2013-2014 онуудад гүйцэтгэхээр гэрээ байгуулж ажилласан. 2013 онд төсөвт тусгагдсан цэвэр усны шугамын ажлыг 100 хувь, 2014 онд насос станцын барилга болон усан сангийн ажлыг 70 хувьтай гүйцэтгэлээ. Уг ажлыг гүйцэтгэхэд зураг зохиогчоос гаргасан зураг төсөл дутуу, техникийн нөхцөлүүд гараагүй, насос станц болон усан санг тэжээх цэвэр усны шугам, цахилгааны эх үүсвэр байхгүй, насос станцын доторхи тоноглол, тоног төхөөрөмж төсөвт өртөгт тусгагдаагүйн учраас хийгдэх боломжгүй болсон. Эдгээр шалтгаануудын улмаас усан сан болон насос станцын туршилт тохируулгыг хийх боломжгүй болж 2015 оны нийслэлийн төсөвт шаардлагатай нэмэлт хөрөнгийг тусгахаар зариалагч болох Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газартай харилцан тохиролцож гэрээг дүгнэн үлдэгдэл хөрөнгийг банкны баталгааг үндэслэн санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн боловч 2015 оны нийслэлийн төсөв, төсвийн тодотгол суулгаж чадаагүйгээр барахгүй 2016 оны нийслэлийн төсөвт ч шаардлагатай байгаа хөрөнгийг тусгуулаагүй нь энэ объектод дахин нэг жил царцах болоод байна.

4. Дорноговь аймгийн Сайншанд хотын 50 ортой төрөх эмнэлгийн барилгын ажлыг 2012 оноос гүйцэтгэж эхэлсэн боловч дараахь шалтгаануудын улмаас өнөөг хүртэл ашиглалтад оруулж чадаагүй байна. Үүнд:

- Барилга угсралтын явцад зайлшгүй хийгдэх ёстой дараахи ажилбарууд
 - * гадна цахилгаан хангамж болон дотор цахилгаан монтаж
 - * хүн болон ачааны лифт
 - * дотор болон гадна шугам сүлжээний ажил

*гадна тохижилтын ажил

* холбоо, дохиололын ажилууд нь анхны тендер шалгаруулалтын ажлын тоо хэмжээнд тусгагдаагүй, захиалагч болох Эрүүл мэндийн яам 2 дугаар ээлжийн ажил болгон дээрхи ажилбаруудаар энэ хугацаанд 3 удаа сонгон шалгаруулалт зарласан боловч дүгнэж чадалгүй хугацаа алдаж 2013, 2014 оны улсын төсөвт суугдсан байсан хөрөнгийг ашиглаж чадалгүй хураалгасанаас үүдэн барилгын ажил зогсонги байдал ороод байна.

Энэ хугацаанд олон удаа үе үеийн Эрүүл мэнд, спортын сайд, яаманы холбогдох алсан тушаалтануудад тухайн барилгад шалгалт хийлгэх, нэмэлт ажлуудад шаардлагатай байгаа санхүүжилтын хэрхэн шийдвэрлэх хандаж байсан боловч ямар ч арга хэмжээ авалгүй 2015 оны 10 сар болгосон бөгөөд 2016 оны 1 сараас эхлэн удаа дараа яам болон Барилгын хөгжлийн төвөөс шалгалтууд хийгдэж тухайн объект нь ашиглалтад орж чадаагүй шалтгааныг тогтоосон бөгөөд эцсийн дүгнэлтээр захиалагч буруутай болох нь тогтоогдсон. Барилгын хөгжлийн төвийн экспертизийн дүгнэлтээр цаашид эмнэлгийн барилгыг бүрэн дуусгаж ашиглалтад оруулахад 1.7 тэрбум төгрөг дутагдаж байгааг дүгнэж улсын 2016 оны улсын төсвийн тодотголд тусгах шаардлагатайг зөвлөсөн байна.

- Санхүү, эдийн засгийн талаар

2015 онд компани улс орны эдийн засаг хүндрэлтэй байсан боловч нөөц бололцоогоо бүрэн дайчлан ажиллаж урд онуудтай харьцуулахад хийж гүйцэтгэсэн барилга угсралтын ажлын өртөг бага байгаа боловч санхүүгийн тайлангаар гарч байгаа нийт борлуулалтын өртөг буураагүй, харин хүлээгдэж байсан ашгийн түвшин харьцангуй бага байлаа. Энэ нь 2013-2014 онд хийж гүйцэтгэсэн зарим барилга угсралтын санхүүжилт хугацаандаа орж ирээгүйгээс банк санхүүгийн байгууллагуудад төлсөн зээлийн хүүгийн төлбөр их байснаас шалтгаалсан гэж үзэж байна.

2014 онд гүйцэтгэсэн 5в магистраль шугам Замын цагдаагийн уулзвараас Континенталь зочид буудлын баруун уулзвар хүртэлх 2400 м ф700-ф800 мм дулааны шугамын өргөтгөлийн ажлын үлдэгдэл 2,8 тэрбум төгрөгийн санхүүжилтыг 2015 онд авах ёстой байсан боловч 2015 оны 1 сарын төсвийн тодотголоор 50 хувь хасагдаж 1,4 тэрбум төгрөгийн 2016 онд санхүүжүүлэхээр болсон нь компанид хүндрэл учруулж, Хаан банк болон бусад санхүүгийн байгууллагаас авсан зээлийг төлж чадахгүйд хүрч зээл төлөлтийн хугацааг сунгаж, энэ хугацаанд 485,7 сая төгрөгийн зээлийн хүү нэмж төлсөн байна. Энэ нь бидний тооцоолж байсан ашиг тэр хэмжээгээр буурч, санхүүгийн төлөвлөгөө алдагдахад хүрсэн гол шалтгаан болж байна. Мөн Сүхбаатар аймгийн Асгат сумын сургуулийн барилга угсралтын ажлыг бүрэн дуусч ашиглалтад хүлээлгэн өгсөн боловч 2015 онд санхүүжих 400 сая төгрөгийн санхүүжилт улсын төсвийн орлого бүрдээгүй шалтгаанаар Сангийн яам ондоо багатааж санхүүжүүлээгүй нь санхүүгийн байдалд ихээхэн хүндрэл учрууллаа.

Компани 2015 онд 5 993,1 сая төгрөгийн борлуулт хийж 40,4 сая төгрөгийн ашигтай ажилласан байна. Нийт борлуулалтын 56% буюу 3358,9 сая төгрөг нь 2015 онд гүйцэтгэсэн

барилга угсралтын ажлынх 44% буюу 2634,2 сая төгрөгийн борлуулалт нь урд онуудад гүйцэтгэсэн ажлын үлдэгдэл санхүүжилт юм

2015 онд татварт 113,0 сая төгрөг, НДШ-д 54,2 сая төгрөг, банк, санхүүгийн байгуулалгад зээлийн хүүгийн зардалд 485,7 сая төгрөг, хөдөлмөр, аюулгүй ажиллагаа, ажлын байрны нөхцөлийг сайжруулахад 57 сая төгрөг, инженер техникийн ажилчдын нийгмийн асуудалыг шийдвэрлэхэд 73 сая төгрөг, хандив, буцатгүй тусламж зэрэгт 21,5 сая төгрөгийг зарцуулсан байна.

- Удирдлага, бүтэц, зохион байгуулалтын талаар

Компани 2015 онд 80 гаруй ажиллагсадтай үйл ажиллагаа явуулсанаас инженер 11, 20 орчим техникийн болон мэргэжлийн ажилчид, 50 гаруй туслах ажилчинтай 2 объектод барилга угсралтын ажлыг гүйцэтгэлээ. 2015 онд залуу инженер, техникийн ажилчид шинэ барилга угсралтын ажлыг хариуцан ажиллаж өөрсдийн мэдлэг боловсрол, удирдан зохион байгуулах чадвараа хамт олондоо харуулж чадлаа. Инженер, менежерүүдийн ажилдаа идэвх зүтгэлтэй, сайн зохион байгуулалтын үрээр гэрээт ажлуудыг хугацаанд нь чанартай гүйцэтгэж ашиглалтанд орууллаа. Ажил гүйцэтгэх явцад урамшууллын олон янзын хэлбэрийг хэрэглэж үүнд 15 сая төгрөгийг зарцуулсан байна. Мөн одоо ажиллаж байгаа инженер, техникийн ажилчид, менежерүүдийг ажилдаа тогтвор сууршилтай ажиллах, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд зориулж орон гэр авах, албан ажил болон хувьд унах зорилготой унаа авахад зориулж 73 сая төгрөгийн дэмжлэг, 30 гаруй сая төгрөгийн тодорхой хугацаатай зээлийг олгож хугацаандаа төлөгдөж байна.

- Сургалт, мэргэжил дээшлүүлэх, нийгмийн ажлын талаар

Өнгөрсөн жил бидний хувьд ахмад инженер техникийн ажилчдынхаа мэргэжлийн ур чадвар, туршлага дээр тулгуурлан залуу боловсон хүчин, инженерүүдийг ажлын байраар хангаж, тэднийг ажилдаа идэвх санаачлагатай, мэргэжлийн ур чадвар гарган ажиллахад ихээхэн дэмжлэг тусалцаа үзүүлэн инженерүүдийг ажлын байраар хангаж, тэднийг ажилдаа идэвх санаачлагатай, мэргэжлийн ур чадвар гарган ажиллахад ихээхэн дэмжлэг тусалцаа үзүүлэн ажиллалаа. Тэднийг мэргэжилдээ эзэн болоход бүхий л нөөц бололцоогоор хангаж ажилласан ба барилгын салбарт боловсон хүчин бэлддэг их, дээд сургуулиудтай хамтран ажиллаж тэдний мэргэжлийг дээшлүүлэхээр 3 инженерийг мэргэшсэн инженерийн сургалтад, 1 инженерийг мэргэшсэн төсөвчиний сургалтад тус тус хамрууллаа.

- Шагнал урамшуулал

2015 онд компанийг Монгол улсын их бүтээн байгуулалтанд мэргэжлийн боловсон хүчин, машин механизм, тоног төхөөрөмжийг ашиглан мэдлэг чадвар, бүхий л нөөц бололцоогоо дайчлан ажилласныг үнэлж БХБЯамны “Тэргүүний ажилтан” цол тэмдэгээр 3 ажилтаныг, Яамны жуух бичгээр 5 ажилтаныг шагнаж урамшууллаа.

Энэ бүгдээс дүгнэн хэлэхэд компанийн гүйцэтгэх удирдлага хэдийгээр 2014 оны сүүл 2015 онд Монгол улсад эдийн засгийн хямралтай, гадаад валютын ханш 40 орчим хувиар өсөж, гүйцэтгэсэн барилга угсралтын ажлын санхүүжилтүүд удаан хугацаагаар саатаж тасалдаж байсан боловч компани энэ бүгдийг даван туулахын тулд тодорхой хэмжээний хэмнэлтийн горимд шилжиж бүхий л нөөц бололцоогоо дайчлан ажиллаж 2015 оны зорилтыг хангалттай биелүүллээ гэж үзэж байна.

Анхаарал тавьсанд баярлалаа.